



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

2021 оны 02 сарын 10 өдөр

Дугаар E/15

Төрийн ордон, Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮДЭД

Улс орон, ард иргэдийнхээ
амьдралд анхаарах тухай

Өнгөрсөн жилийн энэ үед дэлхий нийтийг цочирдуулсан цар тахал олон улсад тархаж, 2020 онд улс орон, ард нийтээрээ эдийн засгийн хямрал, ахуй амьдралын хүндрэл бэрхшээлтэй тулгарах, түүнийг даван туулах зайлшгүй шаардлагатай нүүр тулах нь нэгэнт тодорхой болж байлаа.

Тухайн үед миний бие Улсын Их Хурал болон Засгийн газарт зохих журмын хүрээнд удаа дараа хандаж, алсын хараатай, нэгдмэл зорилгоор ажиллах, төсөв хөрөнгөө бодитойгоор хэмнэх, цар тахлаас урьдчилан сэргийлж тэмцэхээс гадна түүнээс үүдэлтэй эдийн засгийн хүндрэл, хямралыг даван туулах цогц бодлого, төлөвлөгөөг цаг алдалгүй гаргах, хэрэгжүүлэх зэрэг асуудал, шаардлагыг тавьж, санал, санаачилгаа тухай бүр илэрхийлж байсан боловч эрх баригчдын сонгуулийн явцуу зорилго, эрх мэдлийн төлөөх богино бодлогыг давж гараагүй болно.

Харамсалтай нь 2021 он мөн хүндхэн жил болох төлөвтэй байна. Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагааны хүрээнд авч хэрэгжүүлсэн хорио цээрийн дэглэм, хязгаарлалтаас үүдэн ард иргэдийн ажил, орлого тасалдаж амьдрал нь өдрөөс өдөрт дордох, аж ахуй, бизнес, үйлдвэрүүдийн хэвийн үйл ажиллагаа алдагдаж доголдох, дампуурах, улмаар улс орны эдийн засгийн байдал эрс хүндрэн доройтох бодит эрсдэл, аюул нэн ойрхон, нөхцөл байдал туйлын эмзэг, өдөр ирэх тусам, цаг алдах бүрт улсаараа улам хүнд байдалд орохоор байна.

Үүний хажуугаар улс төрийн хүрээний тодорхой бүлэглэл, түүнд хамаарах улс төрчдийн зүгээс явуулж буй хүний санаанд оромгүй, бохир, зохион байгуулалттай, үндэсний эв нэгдлийг бусниулах хэмжээний увайгүй, бас болчимгүй улс төрийн үйл ажиллагаа улс орон, ард иргэдийн амьдралд дарамт нэмж мэдэхээр болж байна.

Шинэ он гарснаас хойших богинохон хугацаанд ганцхан өдрийн дотор Засгийн газрыг огцрууллаа, Улсын Их Хурлын гишүүн өлсгөлөн зарлалаа, Монгол Улсын маань иргэн, улс орны ирээдүй болсон нэгэн залуу төв талбай дээр өөрийгөө шатаан хөнөөлөө.

2021000113

Улс орон, ард иргэдийн амьдрал болоод нийгэм, эдийн засгийн байдал ийм эгзэгтэй, хүнд байхад төрийн эрх барих дээд байгууллага, ард түмний элч болсон Улсын Их Хурлын гишүүд амарч, завсарлаад байж таарахгүй гэж үзэж байна.

Цар тахлын хүнд үед өрх бүрд нэг сая төгрөг олгох, айл өрхүүдээрээ дамжуулан үндэсний үйлдвэрлэл, аж ахуйгаа дэмжих зорилгоор 2021 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр миний өргөн мэдүүлсэн "Коронавируст халдварын цар тахлаас үүдэлтэй амьдралын доройтол, нийгэм, эдийн засгийн бэрхшээлийг даван туулах онцгой арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурал авч хэлэлцэхгүйгээр 2020 оны намрын ээлжит чуулганаа өндөрлүүлсэн.

Мөн стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг эзэмшдэг, их хэмжээний гадаад валютын орлоготой үндэсний болон гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын мөнгөн гүйлгээ, төлбөр тооцоог Монгол Улсын банкаар гүйцэтгэдэг болгох зорилго бүхий Валютын зохицуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурал эцэслэн батлах талаар тодорхой арга хэмжээ авахгүй байсаар 2 жил 2 сарын хугацааг өнгөрүүлээ.

Түүнчлэн Оюутолгойн ордыг тойрсон ноцтой баримт, мэдээллүүд, авлига, албан тушаалын гэмт хэргийн шинжтэй үйлдэл, түүнийг шалгаж буй хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаа болон уг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хамгаалах, хангуулах асуудлын хүрээнд Монголын төр нэгдмэл бодлоготой, Улсын Их Хурлын гишүүд нэгдсэн байр суурь, ойлголттой болох, үүний тулд хууль хяналтын байгууллагын мэдээллийг сонсох бодит шаардлага байгааг харгалзан Улсын Их Хурлын чуулганы хаалттай хуралдаан зохион байгуулах саналыг зохих журмаар хүргүүлсэн боловч бас шийдвэрлэгдээгүй байна.

Миний бие эдгээр гурван асуудлын хүрээнд Улсын Их Хурлын ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулах тухай саналаа 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдөр Улсын Их Хурлын даргад хүргүүлсэн болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Улсын Их Хурлын гишүүдийн гуравны нэгээс дээшгийн шаардсанаар, эсхүл Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын даргын санаачилгаар ээлжит бус чуулган чуулж болно" гэж заасан байдаг.

Иймд Улсын Их Хурлын эрхэм гишүүн Танаас улс орон, ард иргэдийнхээ амьдралд анхаарч, Улсын Их Хурлын ээлжит бус чуулганыг дээрх асуудлын хүрээнд зарлан хуралдуулахад зохих ёсны дэмжлэгийг үзүүлэн, хуульд заасан боломжийн хүрээнд хамтран ажиллахыг хүсэж байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА

